



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/664

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн, хамт олноо манлайлан, олон жил үр бүтээлтэй ажиллаж буй ахлах дэслэгч С.Мөнхтүвшин, ахлах ахлагч Х.Гүнтуган, ахлах ахлагч Ч.Бауржан нарыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 90 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 90 000 төгрөг /ерөн мянга/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ